



МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГААНЫ 2013 ОНЫ ЦАГАЛБАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 37

Төрийн ордон, Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хавсралтаар баталсугай.

2.Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Аптанхуяг/-т даалгасугай:

1/Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж хөтөлбөрийн биелэлтийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулж байх;

2/Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусган хэрэгжүүлэх.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

Монгол улсын Далайн захиргаа нь Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Далайн тээврийн салбарт тэргүүлэгч орнуудтай хамтран далайн тээврийн үйл ажиллагааг эхлүүлж, тухайн салбарт үндэсний ажилтан, мэргэжилтнүүдийг ажиллуулах арга хэмжээ авах зорилттой ажиллаж байна.

Зам, тээврийн Сайдтай 2013 онд байгуулсан Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээний заалтын дагуу үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээ, гүйцэтгэх ажлын биелэлт 2013 оны жилийн эцсийн байдлаар 84.9 хувьтай хэрэгжээд байна.



МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

Далайн тээврийн салбарын хөгжлийн бодлого, шинэчлэлийн чиглэлээр мэдлэгээ дээшлүүлж ажиллалаа. Олон улсын байгууллагуудын шугамаар болон Засгийн газраас зохион байгуулагдах сургалт, семинар, уулзалт, зөвлөгөөнд оролцох, тухайлбал, Олон Улсын Далайн байгууллагаас зохион байгуулсан “хөлөг онгоцны бүртгэлийн тогтолцоо” сургалт, “Мандал даатгал” ХХК-иас зохион байгуулсан эрсдлийн удирдлагын “Макро эрсдэл” сургалт, семинарт тус тус хамрагдсан болно.

Далайн захиргаа нь Олон Улсын Далайн байгууллага (ИМО), Бүгд Найрамдах Солонгос Улсын Далайн хэргийн яам, Далайн тээврийн их сургууль, Загас агнуур, технологийн дээд сургууль, Ази номхон далайн бүсийн техникийн хяналтын байгууллага зэрэг гадаадын болон олон улсын байгууллагуудтай гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, төвийн албан хаагчдын мэргэжлийг дээшлүүлэх, ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах чиглэлээр холбоо тогтоон ажиллаж байна.

Гадаад орнуудын далайн тээврийн салбар дахь төр, хувийн хэвшлийн түншлэл, хувийн хэвшлээс хөрөнгө оруулалт хийх нөхцөл, орчинг судлан ажиллаж байна.



ДАЛАЙН ТЭЭВРИЙН САЛБАРТ МЭРГЭЖИЛТЭН БЭЛТГЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД



ОХУ-ын Владивосток хотын Адмирал Г.И Невельсковын нэрэмжит Далайн их сургуульд (Морской государственной университет имени адмирала Г.И Невельского) 5.5 жилийн хугацаатайгаар 2007 оноос 2013 он хүртэл 3-н оюутан тус тус амжилттай төгссөн.

№	Овог нэр	Мэргэжил	Төгссөн он
1	С.Түвшинтөр	Хөлөг онгоцны ахмад	2013
2	Б.Оргил	Хөлөг онгоцны хөдөлгүүрийн инженер	2013
3	Г.Золбоо	Хөлөг онгоцны цахилгааны инженер	2013





ДАЛАЙН ТЭЭВРИЙН САЛБАРТ МЭРГЭЖИЛТЭН БЭЛТГЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД



Монгол - Солонгосын Засгийн газар хоорондын далайн тээврийн салбар дахь хамтын ажиллагаа, Монгол Улсад далайн салбарыг хөгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн далайчин бэлтгэхэд БНСУ-ын Далайн тээвэр, загас агнуурын технологийн институт (Korea Institute of Maritime and Fisheries Technology)-тэй хамтран ажиллахаар Монголын Далайн захиргаа 2012 оны 3-р сард харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж энэ ажлын эхлэл болгон эхний 10 монгол залуу оюутнууд “OceanPolytech” сургалтанд 2013 оны 3 сараас эхлэн 1.5 жилийн хугацаатайгаар хамрагдаж байна.

№	Овог нэр	Сургалтын хугацаа	Мэргэжил
1	М. Батжаргал	2013.03.01-2014.09.01 БНСУ-ын Далайн тээвэр, загас агнуурын технологийн ИНСТИТУТ	Navigation (5)
2	Б. Түвшин		
3	О. Дашбалбар		
4	Э. Билгүүн		
5	Б. Тунгалаг		
6	С. Наранцэцэг		Engine (5)
7	Б. Дагвасүрэн		
8	Э. Энхбаяр		
9	Б. Дөлгөөн		
10	Ч. Дамдинбазар		



ДАЛАЙН ТЭЭВРИЙН САЛБАРТ МЭРГЭЖИЛТЭН БЭЛТГЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД





ДАЛАЙН ТЭЭВРИЙН САЛБАРТ МЭРГЭЖИЛТЭН БЭЛТГЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД

Ажиллагсдын мэдлэг чадвар дээшлүүлэх сургалтад Сингапур улсад хөлөг онгоц бүртгэлийн арга зүйн давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан мэргэжилтнүүд.

Далайн захиргаа болон ЗТЯ-ны холбогдох хэлтсийн нийт 8 мэргэжилтэн Сингапур улс дахь МХОБ Хамтарсан компани дээр Хөлөг онгоц бүртгэлийн онол болон практик үйл ажиллагаа, ОУДБ-аас зохион байгуулсан “Хөлөг онгоцны осол, аваарыг шинжлэн судлах үйл ажиллагаа” зэрэг сургалтанд (2013 оны 03-08 сард),

№	Овог нэр	Албан тушаал	Сургалтын утга	Сургалтанд хамрагдсан хугацаа
1	Д. Байгалмаа	Ахлах мэргэжилтэн	Хөлөг онгоц бүртгэлийн онол болон практик үйл ажиллагаа	2013.03.04-03.29
2	Д. Мөнхцэцэг	Хуулийн зөвлөх	Хөлөг онгоц бүртгэлийн онол болон практик үйл ажиллагаа	2013.03.04-03.29
3	Б. Далайбаяр	Мэргэжилтэн	Хөлөг онгоц бүртгэлийн онол болон практик үйл ажиллагаа	2013.03.30-04.27
4	Д. Амартүвшин	Мэргэжилтэн	Хөлөг онгоц бүртгэлийн онол болон практик үйл ажиллагаа	2013.03.30-04.27
5	М. Мөнхцэцэг	Мэргэжилтэн	Хөлөг онгоц бүртгэлийн онол болон практик үйл ажиллагаа	2013.04.27-05.25
6	М. Ганцэцэг	ЗТЯ-ны ДАУЗБХЗГ	Хөлөг онгоц бүртгэлийн онол болон практик үйл ажиллагаа	2013.04.27-05.25
7	Д.Байгалмаа	Ахлах мэргэжилтэн	Хөлөг онгоцны осол, аваарыг шинжлэн судлах үйл ажиллагаа	2013.07.21-08.02
8	Б. Оргил	Мэргэжилтэн	Хөлөг онгоцны осол, аваарыг шинжлэн судлах үйл ажиллагаа	2013.07.21-08.02



ДОТООДЫН УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, АЮУЛГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН ХҮРЭЭНД

Усан замын тээврийн тухай хууль, аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиуд болон Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд, Байгаль орчны сайдын хамтарсан 26/58 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Далайн захиргаанаас Хөвсгөл аймгийн хатгал тосгонд “Усан замын тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх улсын дугаар олгох журам”-ын дагуу 2013 оны 6-р сарын 27-ноос эхлэн 7-р сарын 2-ны өдрүүдэд ажиллаж батлагдсан удирдамжийн дагуу дараахь ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны нутаг дэвсгэр дэх Хөвсгөл нууранд нийт 59 усан замын тээврийн хэрэгсэл үйл ажиллагаа явуулсан ба үүнээс:

- 6 хүний суудалтай задгай завь -3
- 8 хүний суудалтай задгай завь -6
- 9 хүний суудалтай задгай завь -1
- 9 хүний суудалтай битүү завь -1
- 10 хүний суудалтай битүү завь -2
- 18 хүний суудалтай катер -1



Нийт 14 тээврийн хэрэгсэл шинээр тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулахаар хүсэлт гаргасны дагуу техникийн үзлэг, хяналт хийж бүртгэлд хамруулсан бөгөөд усан замын тээврийн хэрэгсэл жолоодогчдод сургалт явуулж 18 мэргэжлийн үнэмлэхийг шинээр олгосон. Мэргэжлийн арга зүйн зөвлөгөөгөө болон завь жолоодох гарын авлагаар хангаж ажиллав.



ДОТООДЫН УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, АЮУЛГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН ХҮРЭЭНД



Аялал жуулчлал, зорчигч тээврийн зориулалтаар ашиглагдаж байгаа болон шинээр оруулж ирсэн аж ахуйн нэгж, албан байгууллага ба хувь хүний усан замын тээврийн хэрэгслүүдэд техникийн үзлэг шалгалт хийж, тоо бүртгэл хөтлөн тэдгээрт учирч болзошгүй гэмтэл, зайлшгүй шаардлагатай үед дагалдах багаж, төхөөрөмж аврах хантааз, аврах цагираг, аптек, галын хор зэрэгт аваар ослоос урьдчилан сэргийлэх үүднээс аялалд гарахын өмнө байнга шалгаж байх, стандартын дагуу дагалдах хэрэгслээ суурьлуулах зэрэгт хамтран үзлэг шалгалт хийж шаардлага тавьж ажилласан.





ДОТООДЫН УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, АЮУЛГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН ХҮРЭЭНД

Зорчигчдын амь нас, аюулгүй байдлыг хангах үүднээс 2013 Усан замын тээврийн хэрэгслээр зорчих зорчигчдод зориулагдсан Олон улсын стандартын шаардлага хангасан, Далайд хүний аюулгүй байдлыг хангах SOLAS-74 конвенцид нийцсэн аврах хантаазыг иргэд, албан байгууллагуудад танилцуулж аврах хантаазар хангах арга хэмжээг авсан.



Далайн тээвэр ба дотоодын усан замын тээврийн салбарын талаарх мэдээллийг цахим болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчлан ажиллаж байна.



ДОТООДЫН УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, АЮУЛГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН ХҮРЭЭНД



Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Хөвсгөл нууранд Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэд, албан байгууллага, жуулчны баазуудад зорчигчдын аюулгүй байдлыг хангах үүднээс анхааруулах самбар байршуулах санамж өгч, Хатгал тосгоны Тамгын газар, Онцгой байдлын ерөнхий газар, Улсын тусгай хамгаалалттай

газрын захиргаа болон холбогдох дарга, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах санал дэвшүүлэн бидний ажилд туслалцаа дэмжлэг үзүүлсэн болно.

2013 оны 9 дүгээр сард Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Хөвсгөл нууранд усан замын тэмдэг тэмдэглэгээ түүний гэрлэн дохио, нарны зай, дагалдах хэрэгслийг угсран оноосон цэгүүдэд байршуулах ажлыг туршилтын байдлаар эхний ээлжинд суурьлуулж амжилттай ажилласан.





ХӨЛӨГ ОНГОЦНЫ БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД

2013 оны 02 тоот тушаалаар “Далайн захиргаанд хийсэн шалгалтын явцад гарсан зөрчил дутагдлыг арилгах, ажлын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээ авч ажиллах ажлын хэсэг” байгуулагдаж тодорхой төлөвлөгөө гаргаж ажилласны үр дүнд хөлөг онгоцны бүртгэлийн өдөр тутмын үйл ажиллагаанд тавих хяналт сайжирсан.

Зам тээврийн сайдын 2013 оны 47 дугаар тушаалаар Далайн захиргааны дарга Х.Энхбаатар, хуулийн зөвлөх Д.Мөнхцэцэг, ахлах мэргэжилтэн Д.Байгалмаа нар 2013 оны 3 дугаар сард МХОБ хамтарсан компанид ажиллаж 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдөр байгуулагдсан гэрээний биелэлтийг талууд дүгнэх хуралдааныг Сингапурын талын хувь нийлүүлэгчтэй хийж тодорхой шийдэлд хүрсэн.

Хөлөг онгоцны бүртгэлийн программыг “Болорсофт” ХХК-д захиалан цахим хэлбэрт оруулсан бөгөөд энэхүү программыг ашиглан Сингапур улс дахь бүртгэлийн офист бүртгэгдэж байгаа онгоцыг УБ дахь Далайн захиргааны төв офисоос харах, холбогдох мэдээллийг цаг алдалгүй авах боломжтой болсон.

МХОБ” ХХК-ийн ТУЗ-ийн хурлыг 3 дугаар сард хуралдуулж, орлого, зарлагын тайланд үнэлэлт дүгнэлт өгч, энэ жилийн төсвийг хэлэлцэн баталсан.



SAMMOK SHIPPING





ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД


ИМО (Олон Улсын Далайн байгууллага) -ийн 28 дугаар чуулга уулзалт



Олон улсын далайн байгууллага (ОУДБ) нь 2 жилд нэг удаа ассемблей буюу чуулга уулзалтыг ИБУИНВУ-ын нийслэл Лондон хотод байрлах өөрийн төв байранд зохион байгуулдаг. Тус хуралдаанд ОУДБ-ын гишүүн болох 170 улсын төлөөлөл оролцож ирэх 2 жилд байгууллагыг ямар улсууд тэргүүлэхийг санал хураалтын

зарчмаар шийдвэрлэдэг бөгөөд зохион байгуулалтын болон санхүүгийн асуудлуудыг хэлэлцэж баталдаг.

Энэхүү чуулга уулзалтад Монгол улсыг төлөөлөн Зам Тээврийн яамны Төмөр зам, Далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ё.Манлайбаяр, Монгол Улсын Далайн захиргааны дарга Х.Энхбаатар нар оролцсон болно.





***Анхаарал хандуулсанд
баярлалаа***

2013 он